



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

Монгол Улсын Хөдөлмөрийн зах зээл дэх “COVID-19” цар тахлын нөлөө / 2020 оны II улирал /

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
БҮЛЭГ 1. ЭДИЙН ЗАСАГ, ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	4
БҮЛЭГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧДӨД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ	7
Шимтгэл төлөгч байгууллага	8
Даатгуулагч	9
<i>Албан журмын даатгуулагч</i>	9
<i>Сайн дурын даатгуулагч</i>	10
Ажилгүйдлийн тэтгэмж	13
БҮЛЭГ 3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД НӨЛӨӨЛЖ БУЙ НӨЛӨӨ	15
Ажил хайгч иргэн	15
Бүртгэлтэй ажилгүй иргэн	17
Ажлын байрны захиалга, ажилд зуучилсан иргэн	19
<i>Ажлын байрны захиалга</i>	19
<i>Ажилд зуучлагдсан иргэн</i>	21
БҮЛЭГ 4. ТООЦООЛОГДОХ ЕРӨНХИЙ ТЭНЦВЭРИЙН ЗАГВАР	24
COVID-19 цар тахлын монгол улсын эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх нөлөөний үнэлгээ	29
ДҮГНЭЛТ	32

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол Улсын эдийн засгийн, санхүүгийн зарим үзүүлэлтүүд, 2016-2022.....	5
Хүснэгт 2. Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд, өсөн нэмэгдэхээр	7
Хүснэгт 3. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ААНБ-ын тоо, өсөн нэмэгдэхээр.....	8
Хүснэгт 4. Албан журмын даатгуулагчийн тоо, өсөн нэмэгдэхээр	10
Хүснэгт 5. Сайн дурын даатгуулагчийн тоо, өсөн нэмэгдэхээр	11
Хүснэгт 6. Ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо, зарцуулсан хөрөнгө, өсөн нэмэгдэхээр	13
Хүснэгт 7. Ажил хайж байгаа иргэдийн тоо, өсөн нэмэгдэхээр	15
Хүснэгт 8. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэдийн тоо, өсөн нэмэгдэхээр	19
Хүснэгт 9. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэдийн тоо, 2020 оны 6-р сарын байдлаар.....	23
Хүснэгт 10. 2015 оны макро хүснэгт (ДНБ-д эзлэх хувь)	26
Хүснэгт 11. Үйлдвэрлэлийн бүтэц, хувиар.....	27
Хүснэгт 12. Худалдааны бүтэц, хувиар	27
Хүснэгт 13. Эрэлтийн бүтэц, хувиар	28
Хүснэгт 14. Төсвийн бүтэц, хувиар	28
Хүснэгт 15. Өрхийн орлого, зарлага, хувиар	29
Хүснэгт 16. Хөрөнгө оруулалт/Хадгаламжийн бүтэц, хувиар	29
Хүснэгт 17. Хувилбаруудыг харьцуулах нь: Макро эдийн засгийн хувьсагчид	31

ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1. Экспорт, импорт, тухайн оны мөн үетэй харьцуулснаар, хувиар	4
Зураг 2. Экспорт, тухайн оны мөн үетэй харьцуулснаар, хувиар	4
Зураг 3. Бодит дотоодын нийт бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аргаар, улирлаар, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, хувиар.....	5
Зураг 4. Хөдөлмөрийн зах зээлийн зарим үзүүлэлтүүд, улирлаар	6
Зураг 5. Тухайн сард нэмэгдсэн шимтгэлийн орлого, тэрбум төгрөгөөр	8
Зураг 6. Тухайн сард нэмэгдсэн шимтгэл төлөгч ААНБ-ын тоо, сараар.....	9
Зураг 7. Тухайн сард нэмэгдсэн сайн дурын даатгуулагчийн тоо, сараар.....	11
Зураг 8. Тухайн сард нэмэгдсэн сайн дурын даатгалд хамрагдсан малчид, сараар	12
Зураг 9. Тухайн сард нэмэгдсэн сайн дурын даатгалд хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгч, сараар.....	12
Зураг 10. Тухайн сард нэмэгдсэн ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо, сараар.....	13
Зураг 11. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан нэг хүнд зарцуулсан дундаж хөрөнгө, сая төгрөг, сараар	14
Зураг 12. Ажил хайгч иргэний тоо, сарын эцэст, насны бүлгээр	16
Зураг 13. Ажил хайгч иргэний тоо, сарын эцэст, боловсролын түвшнээр	16
Зураг 14. Бүртгэлтэй ажилгүй иргэний тоо, сарын эцэст, насны бүлгээр	18
Зураг 15. Бүртгэлтэй ажилгүй иргэний тоо, сарын эцэст, боловсролын түвшнээр	18
Зураг 16. Ажлын байрны захиалга, ЭЗҮА-ны салбар, хувиар	20
Зураг 17. Ажлын байрны захиалга, ажил мэргэжлийн ангилал, хувиар	21
Зураг 18. Ажилд зуучлагдсан иргэд, насны бүлгээр	22
Зураг 19. Ажилд зуучлагдсан иргэд, ажил мэргэжлийн ангилал, хувиар.....	22
Зураг 20. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэдийн тоо, 2020 оны 6-р сарын байдлаар.....	23
Зураг 21. Шинжилгээний арга	29
Зураг 22. Бодит ДНБ-ий өсөлт, хувь	30
Зураг 23. Экспортын өсөлт, хувь.....	31

БҮЛЭГ 1. ЭДИЙН ЗАСАГ, ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Дэлхийн эдийн засагт COVID-19 цар тахлаас үүдсэн хямрал үүсээд байна. Энэхүү цар тахалаас үүдэлтэй хямралаас сэргийлэхийн тулд улс орнуудын бодлого тодорхойлогчид шуурхай ажиллаж, гуравдугаар сарын дундуур гэхэд нийт 30 гаруй улсын төв банк бодлогын хүүгээ бууруулаад байна. Тэдгээрийн дотор Монгол банк бодлогын хүүг нэг нэгж хувиар, мөн арилжааны банкуудын заавал байлгах нөөцийг хоёр пунктээр бууруулаад байгаа юм.

Цар тахлын дэгдэлт нь Монгол Улсын эдийн засагт ихээхэн нөлөөлж эхэлсэнийг Үндэсний статистикийн хорооноос гаргасан “Коронавирус ба эдийн засаг” судалгаанаас харж болно. Тухайлбал улсын нэгдсэн төсвийн орлого 2020 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 4 358.7 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 1 190.0 тэрбум төгрөг буюу 21.4 хувиар буурсан байна.


Зураг 1. Экспорт, импорт, тухайн оны мөн үетэй харьцуулснаар, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Мөн экспорт 29.5 хувиар буурснаас шалтгаалан улсын нэгдсэн төсвийн орлогын 23.7 хувийг бүрдүүлдэг эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 347.3 тэрбум төгрөг болж буурсан бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 32.9 хувиар буурсан байна. Манай улсын хувьд төсвийн орлого нь экспортоос шууд хамааралтай ба экспортын орлогод уул уурхайн бүтээгдэхүүн 87.1 хувийг эзэлдэг.


Зураг 2. Экспорт, тухайн оны мөн үетэй харьцуулснаар, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Мөн COVID-19 цах тахлын нөлөөнд өртөж буй салбар бол аялал жуулчлал юм. Цар тахлын улмаас энэ онд дэлхийн аялал жуулчлалын зах зээл 25 хувиар хумигдахаар байгааг Дэлхийн аялал жуулчлалын зөвлөлөөс анхааруулаад байна. Монгол Улсын хувьд аялал, жуулчлалын салбар нь хэдийгээр ДНБ-д харьцангуй бага буюу 5-6 хувийг эзэлдэг боловч түүнийг дагасан тээвэр, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарууд дах ажлын байр, ажлын байрны эрэлт буурах төлөвтэй байна.

Зураг 3. Бодит дотоодын нийт бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аргаар, улирлаар, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

2016 оноос Монгол Улсын эдийн засгийн байдал сайжирч эхэлсэн ба тухайлбал, 2017 оны эдийн засгийн өсөлт 5.3, 2018 онд 7.2 хувьд хүрч нэмэгдсэн билээ. Харин 2019 онд уул уурхайн салбарын экспортоос хамааран өсөлт саарч 5.1 хувь болсон. Дэлхийн банкны төсөөллөөр Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2020 онд 5.6 хувиар өснө гэж таамаглаж байсан бол цар тахлын дэгдэлтийн дараах таамаглалаар -0.5 өсөлттэй байхаар тооцсон байна. Харин ОУВС-ын эдийн засаг, санхүүгийн зарим төсөөллийг COVID-19 цар тахлаас өмнөх болон дараах гэсэн байдлаар Хүснэгт 1-т харууллаа.

Хүснэгт 1. Монгол Улсын эдийн засгийн, санхүүгийн зарим үзүүлэлтүүд, 2016-2022


Үндэсний тооцоо данс	2016	2017	2018	2019	2020*		2021*	2022*
					COVID-19 өмнөх төсөөлөл	Дараах төсөөлөл		
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөг)	23943	27876	32411	36898	42056	39175	46029	52485
Бодит ДНБ-ний өсөлт (%)	1.2	5.3	7.2	5.1	5	-1	8	5.5
Эцсийн хэрэглээ	-0.2	3.9	10.1	11.4	8.3	3.5	6.4	6.3
Өрхийн	-2.6	5.4	12.4	10.9	7.3	1.7	5.4	6.6
Засгийн газрын	10.6	-1.8	0.5	13.6	12.9	11.7	10.6	5.1
Хөрөнгө оруулалт	2.1	34.6	18.6	17.9	16.6	-1.9	18	3.4
Экспорт (бараа үйлчилгээний)	13.8	14.8	24	9.9	2.7	-10.2	24.7	10.2
Импорт (бараа үйлчилгээний)	12.7	24.8	30.9	19.1	9.8	-5.6	24	9
Нийт хадгаламж	26	21.3	22.8	20.3	31.3	17.7	24.1	24.1
Засгийн газар	-3.6	3.1	8.4	9.9	8.2	1	5.6	5.5
Хувийн	29.6	18.2	14.4	10.4	23	16.7	18.5	18.6
Үнэ								
Хэрэглээний үнийн индекс	1.3	6.3	8.2	5.2	7.4	6	6.8	7.6
Нүүрс (АНУ доллар, тонн)	4868	6170	6530	6010	6144	5021	4877	4943

Алт (АНУ доллар, унци)	1248	1257	1269	1392	1565	1640	1667	1684
Түүхий нефть (АНУ доллар, баррель)	42.8	52.8	68.3	61.4	62.8	35.6	37.9	40.9
ДНБ дефлятор	2.2	10.5	8.4	8.3	7.1	7.2	8.8	8.1
Төлбөрийн тэнцэл								
Урсгал данс	-6.3	-10.1	-16.8	-15.6	-12.9	-15.8	-11.3	-9.8
Экспорт (өсөлт, %)	4.1	21.4	12.4	9.6	-1.9	-25.5	27.2	6.7
Импорт (өсөлт, %)	0.8	25.3	35.4	2.4	2.9	-17.2	9.4	3
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллараар)	1297	3012	3542	4348	4502	3256	3127	2897

Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, ОУ-ын Валютын сан

Хөдөлмөрийн зах зээлийн зарим үзүүлэлтээс харахад 2020 оны нэгдүгээр улирлын байдлаар ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар буураад байна. Харин ажиллагчдын тоо 1 170.4 мянгад хүрч 2.3 хувиар өссөн бол ажилгүйдлийн түвшин ажиллагчдын тооны өсөлтөөс хамааран 6.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 5.2 пунктээр буурсан байна.

Зураг 4. Хөдөлмөрийн зах зээлийн зарим үзүүлэлтүүд, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

БҮЛЭГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧДӨД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч аж ахуй, нэгж байгууллагын тоо 2020 оны 6 сарын байдлаар 46.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.9 мянга буюу 4.2 хувиар нэмэгдсэн байна. Харин нийт даатгуулагчийн тоо 2020 оны 6 сарын байдлаар 961.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 0.8 мянга буюу 0.1 хувиар буурсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2020 оны 6 сарын байдлаар 721.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 107.3 тэрбум төгрөг буюу 12.9 хувиар буурсан байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын 568.1 тэрбум (78.7 хувь) нь тэтгэврийн, 70.3 тэрбум (9.7 хувь) нь тэтгэмжийн, 67.8 тэрбум (9.4 хувь) нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, 15.4 тэрбум (2.1 хувь) нь ажилгүйдлийн даатгалын сангийн орлого байна.

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд, өсөн нэмэгдэхээр

Он сар	Шимтгэл төлөгч ААНБ-ын тоо	Нийт даатгуулагч	НД-ын шимтгэлийн орлого, сая төгрөг
2019.01	10 987	184 599	115 962.1
2019.02	37 560	741 813	242 190.4
2019.03	42 055	844 403	380 302.6
2019.04	43 001	874 843	519 756.8
2019.05	43 943	919 970	664 560.8
2019.06	44 844	962 480	828 940.3
2019.07	45 362	997 357	961 555.8
2019.08	45 793	1026 006	1 093 095.3
2019.09	46 331	1063 659	1 241 325.5
2019.10	46 905	1101 294	1 384 403.3
2019.11	47 451	1138 141	1 523 339.2
2019.12	47 929	1168 337	1 736 217.0
2020.01	9 692	184 179	131 792.3
2020.02	39 687	762 946	271 363.0
2020.03	42 862	831 943	420 501.2
2020.04	44 636	868 636	520 240.7
2020.05	46 206	924 841	618 136.7
2020.06	46 762	961 692	721 659.1

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар


Тэтгэврийн даатгалын сан: Тэтгэврийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 2020 оны 6 сарын байдлаар 568.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 85.0 тэрбум төгрөг буюу 13.0 хувиар буурсан байна.

Тэтгэмжийн даатгалын сан: Тэтгэмжийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 2020 оны 6 сарын байдлаар 70.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.8 тэрбум төгрөг буюу 13.3 хувиар буурсан байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан: Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн шимтгэлийн орлого 2020 оны 6 сарын байдлаар 67.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.4 тэрбум төгрөг буюу 12.1 хувиар буурсан байна.

Ажилгүйдлийн даатгалын сан: Ажилгүйдлийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 2020 оны 6 сарын байдлаар 15.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.1 тэрбум төгрөг буюу 11.8 хувиар буурсан байна.

Зураг 5. Тухайн сард нэмэгдсэн шимтгэлийн орлого, тэрбум төгрөгөөр



Шимтгэл төлөгч байгууллага

Нийгмийн даатгалд 2020 оны 6-р сарын байдлаар 46 752 аж ахуй, нэгж байгууллага шимтгэл төлсөн бөгөөд 42 185 (90.2 хувь) нь хувийн, 4 577 (9.8 хувь) нь төсөвт байгууллага байна. Шимтгэл төлөгч аж ахуйн нэгж байгууллагын тоо өмнөх оны мөн үеэс 1 918 буюу 4.3 хувиар, өмнөх улирлаас 3 900 буюу 9.1 хувиар өссөн байна.

Шимтгэл төлсөн хувийн ААНБ-ын өмнөх оны мөн үеэс 1 886 буюу 4.7 хувиар, өмнөх улирлаас 3 899 буюу 10.2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ААНБ-ын тоо, өсөн нэмэгдэхээр

Он, сар	Шимтгэл төлөгч байгууллагын тоо	Нэмэгдсэн		Төсөвт байгууллага		
		Нэмэгдсэн	Хувийн ААНБ	Нэмэгдсэн	Нэмэгдсэн	
2019.01	10 987	10 987	9 970	9 970	1 017	1 017
2019.02	37 560	26 573	33 283	23 313	4 277	3 260
2019.03	42 055	4 495	37 355	4 072	4 700	423
2019.04	43 001	946	38 466	1 111	4 535	- 165
2019.05	43 943	942	39 403	937	4 540	5
2019.06	44 844	901	40 299	896	4 545	5
2019.07	45 362	518	40 808	509	4 554	9
2019.08	45 793	431	41 237	429	4 556	2
2019.09	46 331	538	41 767	530	4 564	8
2019.10	46 905	574	42 334	567	4 571	7
2019.11	47 451	546	42 883	549	4 568	- 3
2019.12	47 929	478	43 353	470	4 576	8
2020.01	9 692	9 692	8 493	8 493	1 199	1 199
2020.02	39 687	29 995	35 303	26 810	4 384	3 185
2020.03	42 862	3 175	38 286	2 983	4 576	192
2020.04	44 636	1 774	40 069	1 783	4 567	- 9
2020.05	46 206	1 570	41 632	1 563	4 574	7
2020.06	46 762	556	42 185	553	4 577	3


Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Эхний 3 сарын байдлаар нийт 42 862 шимтгэл төлсөн ААНБ байсан бөгөөд 6 сарын байдлаар 46 762 болж 3 900 аж ахуй, нэгж байгууллагаар нэмэгдсэн байна. Нэмэгдсэн

ААНБ-ыг сараар нь авч үзвэл, 4-р сард 1 774, 5-р сард 1 570, 6-р сард 556 байгууллагаар тус бүр нэмэгджээ.

Тухайн сард нэмэгдсэн шимтгэл төлөгч аж ахуй, нэгж байгууллагын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулж харахад, 2020 оны 3-р сард өмнөх оны мөн үеэс 1320 (29.4 хувь)-аар буурсан, 2020 оны 4-р сард өмнөх оны мөн үеэс 828 (87.5 хувь)-аар, 2020 оны 5-р сард өмнөх оны мөн үеэс 628 (66.7 хувь)-аар өссөн дүнтэй байна. Харин 2020 оны 6-р сард өмнөх оны мөн үеэс 345 (38.3 хувь)-аар буурчээ. Тоон мэдээллээс үзэхэд Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 2-р сарын 19-ний өдрийн хуралдаанаар “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн хугацааг 3-р сарын 30-ныг хүртэл сунгасан нь зарим ААНБ-уудын шимтгэл төлөлтөд нөлөөлсөн байх магадлалтай харагдаж байна. Харин 2020 оны 3-р сарын 27-ны Засгийн газрын ээлжит бус хуралдаанаар дөрөвдүгээр сарын 1-ээс аравдугаар сарын 1-ний өдөр хүртэл аж ахуй, нэгж байгууллагуудын шимтгэлийг тэглэх шийдвэр гарсантай холбоотойгоор 4 болон 5 саруудад нийгмийн даатгалын шимтгэл төлсөн аж ахуй, нэгж байгууллагуудын тоо нэмэгдсэн байна.

Зураг 6. Тухайн сард нэмэгдсэн шимтгэл төлөгч ААНБ-ын тоо, сараар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Даатгуулагч

Нийгмийн даатгалд даатгуулагч 2020 оны 6-р сарын байдлаар 961.7 мянган болж, өмнөх оны мөн үеэс 788 буюу 0.1 хувиар буурсан байна. Нийт даатгуулагчдын 805.1 мянга (83.7 хувь) нь албан журмын, 156.6 мянга (16.3 хувь) нь сайн дурын даатгуулагч байна.

Албан журмын даатгуулагч

Албан журмын даатгуулагчид 2020 оны 6-р сарын байдлаар 805.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.5 мянга буюу 0.4 хувиар өсөхөд хувийн аж ахуй, нэгж байгууллагын даатгуулагчид 556.3 мянга болж, 0.3 хувиар, төсөвт байгууллагын даатгуулагчид 248.8 мянга болж, 0.7 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. Албан журмын даатгуулагчид өмнөх оны мөн үеэс 3.5 мянгаар өссөн бөгөөд өсөлтийн 49.4 хувь нь хувийн аж ахуй нэгжийн байгууллагын, 50.6 хувь нь төсөвт байгууллагын даатгуулагчдын өөрчлөлт байна. Харин албан журмын даатгуулагчдын 556.3 мянга (69.1 хувь) нь хувийн аж ахуй, нэгж байгууллагын, 248.8 мянга (30.9 хувь) нь төсөвт байгууллагын ажиллагчид байна.

Хувийн аж ахуй, нэгж байгууллагын даатгуулагчид 556.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.7 мянга буюу 0.3 хувиар, өмнөх улирлаас 69.4 мянга буюу 11.2 хувиар өссөн байна.

Харин төсөвт байгууллагын даатгуулагчид 248.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.7 мянга буюу 0.7 хувиар, өмнөх улирлаас 11.8 мянга буюу 5.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 4. Албан журмын даатгуулагчийн тоо, өсөн нэмэгдэхээр

Он сар	Албан журмын даатгуулагч	Нэмэгдсэн	Хувийн ААНБ-ын даатгуулагч		Төсөвт байгууллага	Нэмэгдсэн
				Нэмэгдсэн		
2019.01	150 079	150 079	99 392	99 392	50 687	50 687
2019.02	644 584	494 505	429 691	330 299	214 893	164 206
2019.03	705 243	60 659	470 921	41 230	234 322	19 429
2019.04	728 484	23 241	495 083	24 162	233 401	- 921
2019.05	766 130	37 646	526 071	30 988	240 059	6 658
2019.06	801 569	35 439	554 546	28 475	247 023	6 964
2019.07	832 321	30 752	580 593	26 047	251 728	4 705
2019.08	857 533	25 212	602 444	21 851	255 089	3 361
2019.09	889 767	32 234	627 684	25 240	262 083	6 994
2019.10	923 152	33 385	653 995	26 311	269 157	7 074
2019.11	956 309	33 157	680 060	26 065	276 249	7 092
2019.12	982 351	26 042	699 970	19 910	282 381	6 132
2020.01	142 390	142 390	77 979	77 979	64 411	64 411
2020.02	681 644	539 254	455 547	377 568	226 097	161 686
2020.03	723 901	42 257	486 890	31 343	237 011	10 914
2020.04	747 697	23 796	508 458	21 568	239 239	2 228
2020.05	780 517	32 820	535 898	27 440	244 619	5 380
2020.06	805 068	24 551	556 274	20 376	248 794	4 175

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Сайн дурын даатгуулагч

Сайн дурын даатгуулагчид 2020 оны 6-р сарын байдлаар 156.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 4.3 мянга буюу 2.7 хувиар буурсан. Харин өмнөх улирлаас 48.6 мянга буюу 45.0 хувиар өссөн байна. 2020 оны 6 сард шинээр 12.3 мянган хүн сайн дурын даатгалд хамрагдсан бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.2 мянга буюу 73.9 хувиар өссөн байна.

Сайн дурын даатгуулагчийн 46.0 мянга (29.4 хувь) нь малчид, 21.0 мянга (13.4 хувь) нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, үлдсэн 89.6 мянга (57.2 хувь) нь бусад төрлийн даатгуулагч байна.

Малчид: Сайн дураар даатгуулсан малчид 2020 оны 6 сарын байдлаар 46.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 4.5 мянга буюу 10.9 хувиар, өмнөх улирлаас 20.0 мянга буюу 77.3 хувиар нэмэгдсэн байна. 2020 оны 6 сард шинээр 5.1 мянган малчид сайн дурын даатгалд хамрагдсан бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 мянга буюу хоёр дахин өссөн байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч: Сайн дураар даатгуулсан хувиараа хөдөлмөр эрхлэгч 2020 оны 6 сарын байдлаар 21.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 4.2 мянга буюу 16.7 хувиар буурсан. Харин өмнөх улирлаас 4.9 мянга буюу 30.1 хувиар нэмэгдсэн байна. 2020 оны 6 сард шинээр 918 хувиараа хөдөлмөр эрхлэгч сайн дурын даатгалд хамрагдсан бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 249 буюу 37.2 хувиар өссөн байна.


Хүснэгт 5. Сайн дурын даатгуулагчийн тоо, өсөн нэмэгдэхээр

Он, сар	Сайн дурын даатгуулагчийн тоо	Нэмэгдсэн	Малчдын тоо	Хувиараа хөдөлмөр эрхлэгчд		
				Нэмэгдсэн	Хөдөлмөр эрхлэгчд	Нэмэгдсэн
2019.01	34 520	34 520	5 518	5 518	6 821	6 821
2019.02	97 229	62 709	24 020	18 502	15 876	9 055
2019.03	139 160	41 931	33 967	9 947	23 007	7 131
2019.04	146 359	7 199	36 389	2 422	23 931	924
2019.05	153 840	7 481	38 940	2 551	24 556	625
2019.06	160 911	7 071	41 495	2 555	25 225	669
2019.07	165 036	4 125	42 808	1 313	25 564	339
2019.08	168 473	3 437	43 012	204	25 931	367
2019.09	173 892	5 419	43 652	640	26 813	882
2019.10	178 142	4 250	44 034	382	27 397	584
2019.11	181 832	3 690	44 529	495	27 779	382
2019.12	185 986	4 154	45 215	686	28 008	229
2020.01	41 789	41 789	10 549	10 549	6 142	6 142
2020.02	81 302	39 513	18 993	8 444	12 273	6 131
2020.03	108 042	26 740	25 962	6 969	16 149	3 876
2020.04	120 939	12 897	31 050	5 088	17 398	1 249
2020.05	144 324	23 385	40 969	9 919	20 084	2 686
2020.06	156 624	12 300	46 028	5 059	21 002	918

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Сайн дурын даатгуулагч 2019 оны 2-р улиралд 21.8 мянгаар нэмэгдэж байсан бол 2020 оны 2-р улиралд 48.5 мянгаар нэмэгдсэн бөгөөд өмнөх оны 2-р улирлаас 2.2 дахин өссөн байна. Тоон мэдээллээс харахад 2020 оны 3-р сарын 27-ны Засгийн газрын ээлжит бус хуралдаанаар дөрөвдүгээр сарын 1-ээс аравдугаар сарын 1-ний өдөр хүртэл сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөнд тооцно гэсэн шийдвэрийн нөлөөг харж болохоор байна. Жишээлбэл, 2019 оны 4-р сард 7.2 мянга сайн дурын даатгуулагчаар нэмэгдэж байсан бол 2020 оны 4-р сард 12.9 мянгаар нэмэгдсэн бөгөөд өмнөх оны 4-р сараас 5.7 мянга буюу 79.1 хувиар их байна. Мөн 2019 оны 5-р сард 7.5 мянга сайн дурын даатгуулагчаар нэмэгдэж байсан бол 2020 оны 5-р сард 23.4 мянгаар нэмэгдсэн байна. Сайн дурын даатгалд шинээр хамрагдсан даатгуулагчийн тоо өмнөх оны 5-р сараас 3.1 дахин нэмэгдсэн байна.


Зураг 7. Тухайн сард нэмэгдсэн сайн дурын даатгуулагчийн тоо, сараар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Малчид: Сайн дурын даатгалд хамрагдсан малчид 2019 оны 2-р улиралд 7.5 мянгаар нэмэгдэж байсан бол 2020 оны 2-р улиралд 20.1 мянгаар нэмэгдсэн бөгөөд өмнөх оны 2-р улирлаас 2.7 дахин өссөн байна.


Зураг 8. Тухайн сард нэмэгдсэн сайн дурын даатгалд хамрагдсан малчид, сараар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Хувиараа хөдөлмөр эрхлэгч: Сайн дурын даатгалд хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгч 2019 оны 2-р улиралд 2.2 мянгаар нэмэгдэж байсан бол 2020 оны 2-р улиралд 4.8 мянгаар нэмэгдсэн бөгөөд өмнөх оны 2-р улирлаас 2.2 дахин өссөн байна.

Зураг 9. Тухайн сард нэмэгдсэн сайн дурын даатгалд хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгч, сараар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Ажилгүйдлийн тэтгэмж

Ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо 2020 оны 6 сарын байдлаар 10.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 106 буюу 0.1 хувиар буурсан байна. Харин өмнөх улирлаас 5.3 мянга буюу 1.6 хувиар нэмэгдсэн байна. Харин 2020 оны 6 сарын байдлаар ажилгүйдлийн тэтгэмжид 26 055.2 сая төгрөг зарцуулсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 6867.2 сая төгрөг буюу 35.8 хувиар өссөн байна.


Хүснэгт 6. Ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо, зарцуулсан хөрөнгө, өсөн нэмэгдэхээр

Он сар	Хүний тоо		Зарцуулсан хөрөнгө, сая.төг	
		Нэмэгдсэн		Нэмэгдсэн
2019.01	2 010	2 010	3 427.3	3 427.3
2019.02	3 385	1 375	6 143.2	2 715.9
2019.03	5 043	1 658	9 022.2	2 879.1
2019.04	6 971	1 928	12 258.4	3 236.2
2019.05	8 886	1 915	16 182.6	3 924.2
2019.06	10 728	1 842	19 188.0	3 005.4
2019.07	12 654	1 926	22 816.6	3 628.6
2019.08	14 401	1 747	26 020.9	3 204.3
2019.09	16 874	2 473	30 742.8	4 721.9
2019.10	19 230	2 356	34 570.0	3 827.2
2019.11	21 105	1 875	39 245.7	4 675.7
2019.12	23 033	1 928	43 549.8	4 304.1
2020.01	2 076	2 076	4 949.0	4 949.0
2020.02	3 662	1 586	8 750.5	3 801.5
2020.03	5 268	1 606	12 897.0	4 146.5
2020.04	7 498	2 230	17 040.3	4 143.3
2020.05	9 376	1 878	21 629.3	4 589.0
2020.06	10 622	1 246	26 055.2	4 425.9

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

2019 оны эхний хагас жилийн байдлаар сард дунджаар 1 788 хүн ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдаж, ажилгүйдлийн тэтгэмжийн сангаас 3 198.0 сая төгрөг зарцуулж байсан бол 2020 оны хагас жилийн байдлаар сард дунджаар 1 770 хүн ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдаж, ажилгүйдлийн тэтгэмжийн сангаас 4 342.5 сая төгрөг зарцуулсан байна. Сард дунджаар ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан хүний тоо өмнөх оноос 18-аар буурсан хэдий ч, ажилгүйдлийн тэтгэмжийн сангаас зарцуулсан хөрөнгө 1 144.5 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна.


Зураг 10. Тухайн сард нэмэгдсэн ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо, сараар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

2019 оны хагас жилийн байдлаар ажилгүйдлийн тэтгэмж авсан нэг хүнд дунджаар 1.8 сая төгрөг зарцуулж байсан бол 2020 оны хагас жилийн байдлаар 2.5 сая болж 0.7 саяаар (37.1 хувь) нэмэгдсэн байна. Ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо буурсан хэдий ч ажилгүйдлийн тэтгэмжийн зардал өссөн. Эндээс үзэхэд өндөр цалин, хөлстэй ажиллагчид ажлаасаа гарч ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан байх магадлалтай юм.

Зураг 11. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан нэг хүнд зарцуулсан дундаж хөрөнгө, сая төгрөг, сараар



БҮЛЭГ 3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД НӨЛӨӨЛЖ БҮЙ НӨЛӨӨ**Ажил хайгч иргэн**

2020 оны 6 сарын эхэнд 31.4 мянган хүн ажил хайж байсан бол тайлант хугацаанд 9.3 мянган ажил хайгч нэмэгдэж, 10.0 мянган хүн хасагдсан байна. Тайлант хугацаанд хасагдсан ажил хайгчийн 4.1 мянгаар буюу 40.6 хувь нь ажилд зуучлагдсан байна. 2020 оны 6 сарын эцэст 30.3 мянган ажил хайгч үлдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 3.0 мянга буюу 9.0 хувиар буурсан байна. Мөн сарын эцэст ажил хайж байгаа иргэдийн 555 буюу 1.8 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн 2020 оны 6 сарын байдлаар 9.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 5.1 мянга буюу 35.4 хувиар буурсан байна.

Тайлант хугацаанд хасагдсан иргэн 2020 оны 6 сарын байдлаар 10.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 6.3 мянга буюу 38.5 хувиар буурсан байна.

Ажилд зуучлагдсан иргэн 2020 оны 6 сарын байдлаар 4.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.6 мянга буюу 39.2 хувиар буурсан байна.


Хүснэгт 7. Ажил хайж байгаа иргэдийн тоо, өсөн нэмэгдэхээр

Он сар	Ажил хайгч /сарын эхэнд/		Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн		Тайлант хугацаанд хасагдсан иргэн	Ажилд зуучлагдсан	Ажил хайгч /сарын эцэст/	
		Эмэгтэй		Эмэгтэй				Эмэгтэй
2019.01	36 169	19 035	8 129	4 191	9 620	1 554	34 678	18 056
2019.02	34 678	18 056	7 005	3 718	7 705	1 116	33 978	17 734
2019.03	33 978	17 734	8 653	4 451	10 799	1 384	31 832	16 466
2019.04	31 832	16 466	10 306	5 391	9 164	2 736	32 974	17 100
2019.05	32 974	17 100	11 588	5 328	9 219	3 793	35 343	18 140
2019.06	35 343	18 140	14 319	7 783	16 335	6 712	33 327	17 255
2019.07	33 327	17 255	9 546	4 822	9 949	2 013	32 924	17 075
2019.08	32 924	17 075	8 506	4 500	10 599	2 132	30 831	16 165
2019.09	30 831	16 165	11 472	6 357	11 836	3 812	30 467	16 250
2019.10	30 467	16 250	17 570	8 993	13 407	5 540	34 630	18 388
2019.11	34 630	18 388	15 210	7 451	13 777	5 817	36 063	18 969
2019.12	36 063	18 969	17 229	8 764	16 248	7 246	37 044	19 016
2020.01	37 044	19 016	10 097	5 256	9 993	1 775	37 148	19 275
2020.02	37 148	19 275	6 648	3 260	8 172	1 131	35 624	18 341
2020.03	35 624	18 341	7 040	3 546	10 879	1 794	31 785	16 285
2020.04	31 785	16 285	11 627	5 686	10 405	2 777	33 007	16 651
2020.05	33 007	16 651	9 765	4 454	11 658	3 905	31 114	15 648
2020.06	31 114	15 648	9 257	4 656	10 051	4 079	30 320	15 367

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2020 оны 6 сарын эцэст 30.3 мянган иргэн ажил хайгч байгаа бөгөөд насны бүлгээр нь авч үзвэл, 6.0 мянга (18.0 хувь) нь 15-24 насныхан, 10.4 мянга (31.2 хувь) нь 25-34 насныхан, 7.8 мянга (23.4 хувь) нь 35-44 насныхан, 4.9 мянга (14.6 хувь) нь 45-54 насныхан, 0.9 мянга (2.8 хувь) нь 55-59 насныхан, 0.3 мянга (1.0 хувь) нь 60 ба түүнээс дээш насныхан байна.


Зураг 12. Ажил хайгч иргэний тоо, сарын эцэст, насны бүлгээр



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2020 оны 6 сарын эцэст ажил хайгч иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 0.5 мянга (1.5 хувь) нь боловсролгүй, 0.7 мянга (2.3 хувь) нь бага, 2.0 мянга (6.7 хувь) нь суурь, 17.2 мянга (56.8 хувь) нь бүрэн дунд, 2.0 мянга (6.7 хувь) нь техникийн болон мэргэжлийн, 1.3 мянга (4.4 хувь) нь тусгай мэргэжлийн дунд, 6.3 мянга (20.6 хувь) нь дипломын болон бакалаврын дээд, 0.23 мянга (0.8 хувь) нь магистр, докторын зэрэгтэй байна.

Зураг 13. Ажил хайгч иргэний тоо, сарын эцэст, боловсролын түвшнээр



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Бүртгэлтэй ажилгүй иргэн

2020 оны 6 сарын эхэнд 19.8 мянган бүртгэлтэй ажилгүй иргэн байсан бол тайлант хугацаанд 5.6 мянгаар нэмэгдэж, 5.8 мянган хүнээр хасагдаж сарын эцэст 19.6 мянган иргэн үлдсэн байна. Тайлант хугацаанд хасагдсан бүртгэлтэй ажилгүй иргэний 2.2 мянгаар буюу 38.0 хувь нь ажилд зуучлагдсан байна. 2020 оны 6 сарын эцэст 19.6 мянган бүртгэлтэй ажилгүй иргэн байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 3.5 мянга буюу 15.1 хувиар буурсан байна. Мөн сарын эцэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн 369 буюу 1.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн 2020 оны 6 сарын байдлаар 5.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.5 мянга буюу 38.3 хувиар буурсан байна.

Тайлант хугацаанд хасагдсан иргэн 2020 оны 6 сарын байдлаар 5.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.7 мянга буюу 38.9 хувиар буурсан байна.

Ажилд зуучлагдсан иргэн 2020 оны 6 сарын байдлаар 2.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.3 мянга буюу 36.3 хувиар буурсан байна


Хүснэгт 4. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, өсөн нэмэгдэхээр

Он сар	Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эхэнд/		Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн		Тайлант хугацаанд хасагдсан иргэн	Ажилд зуучлагдсан	Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/	
	Эмэгтэй	Эмэгтэй	Эмэгтэй	Эмэгтэй			Эмэгтэй	Эмэгтэй
2019.01	24 964	13 222	5 690	2 956	6 250	1 030	24 404	12 800
2019.02	24 404	12 800	5 143	2 755	5 524	774	24 023	12 653
2019.03	24 023	12 653	5 355	2 795	7 626	897	21 752	11 331
2019.04	21 752	11 331	6 996	3 708	6 279	1 767	22 469	11 747
2019.05	22 469	11 747	7 242	3 403	6 202	2 330	23 509	12 232
2019.06	23 509	12 232	9 110	4 929	9 574	3 487	23 045	12 165
2019.07	23 045	12 165	6 272	3 242	6 903	1 281	22 414	11 918
2019.08	22 414	11 918	5 663	3 079	6 751	1 486	21 326	11 408
2019.09	21 326	11 408	7 281	4 117	8 194	2 439	20 413	11 041
2019.10	20 413	11 041	10 222	5 227	8 719	3 628	21 916	11 746
2019.11	21 916	11 746	7 917	3 871	8 692	3 380	21 141	11 214
2019.12	21 141	11 214	10 145	5 391	10 525	4 699	20 761	10 887
2020.01	20 761	10 887	6 285	3 262	6 434	1 115	20 612	10 891
2020.02	20 612	10 891	4 464	2 240	4 433	709	20 643	10 836
2020.03	20 643	10 836	4 418	2 274	5 667	1 117	19 394	10 009
2020.04	19 394	10 009	7 739	3 853	6 477	1 763	20 656	10 549
2020.05	20 656	10 549	6 092	2 771	6 959	2 277	19 789	10 012
2020.06	19 789	10 012	5 621	2 838	5 847	2 221	19 563	10 001

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2020 оны 6 сарын эцэст 19.6 мянган бүртгэлтэй ажилгүй иргэн байгааг насны бүлгээр нь авч үзвэл, 3.6 мянга (18.4 хувь) нь 15-24 насныхан, 7.2 мянга (36.9 хувь) нь 25-34 насныхан, 4.9 мянга (25.3 хувь) нь 35-44 насныхан, 3.0 мянга (15.4 хувь) нь 45-54 насныхан, 0.6 мянга (3.0 хувь) нь 55-59 насныхан, 0.2 мянга (1.0 хувь) нь 60 ба түүнээс дээш насныхан байна.


Зураг 14. Бүртгэлтэй ажилгүй иргэний тоо, сарын эцэст, насны бүлгээр



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2020 оны 6 сарын эцэст бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 0.3 мянга (1.4 хувь) нь боловсролгүй, 0.5 мянга (2.3 хувь) нь бага, 1.3 мянга (6.6 хувь) нь суурь, 10.3 мянга (52.5 хувь) нь бүрэн дунд, 1.5 мянга (7.9 хувь) нь техникийн болон мэргэжлийн, 0.9 мянга (4.7 хувь) нь тусгай мэргэжлийн дунд, 4.6 мянга (23.7 хувь) нь дипломын болон бакалаврын дээд, 0.6 мянга (0.8 хувь) нь магистр, докторын зэрэгтэй байна.

Зураг 15. Бүртгэлтэй ажилгүй иргэний тоо, сарын эцэст, боловсролын түвшнээр



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажлын байрны захиалга, ажилд зуучилсан иргэн

2020 оны 6 сарын байдлаар 28.0 мянган ажлын байрны захиалга ирсэн бөгөөд, өмнөх оны мөн үеэс 1.0 мянга буюу 3.7 хувиар, өмнөх улирлаас 20.4 мянга буюу 2.7 дахин нэмэгдсэн байна. 2020 оны 6 сард шинээр 6.7 мянган ажлын байрны захиалга ирсэн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.2 мянга буюу 32.5 хувиар буурсан байна.

Мөн 2020 оны 6 сарын байдлаар 15.3 мянган иргэн ажилд зуучлагдсан бол, өмнөх оны мөн үеэс 1.6 мянга буюу 9.8 хувиар буурсан байна. Харин өмнөх улирлаас 10.8 мянга буюу 2.4 дахин нэмэгдсэн байна. 2020 оны 6 сард шинээр 7.6 мянган иргэн ажилд зуучлагдсан бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 мянга буюу 15.4 хувиар буурсан байна. 2019 оны 6 сард жилд зуучлагдсан иргэдийн 51.2 хувь нь эмэгтэйчүүд байсан бол 2020 оны 6 сарын байдлаар 48.1 хувь болж 3.1 пунктээр буурсан байна.

Хүснэгт 8. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэдийн тоо, өсөн нэмэгдэхээр

Он сар	Ажлын байрны захиалга		Ажилд зуучилсан иргэн		
		Нэмэгдсэн		Эмэгтэй	Нэмэгдсэн
2019.01	2 224	2 224	1 161	627	1 161
2019.02	4 119	1 895	2 277	1 221	1 116
2019.03	6 710	2 591	3 661	1 977	1 384
2019.04	11 964	5 254	6 397	3 403	2 736
2019.05	17 139	5 175	10 191	4 927	3 794
2019.06	27 037	9 898	16 903	8 662	6 712
2019.07	31 327	4 290	18 916	9 593	2 013
2019.08	34 402	3 075	21 048	10 720	2 132
2019.09	39 989	5 587	24 860	12 738	3 812
2019.10	47 190	7 201	30 537	15 574	5 677
2019.11	55 849	8 659	36 436	18 374	5 899
2019.12	71 124	15 275	44 059	22 244	7 623
2020.01	2 795	2 795	1 398	713	1 398
2020.02	5 098	2 303	2 695	1 393	1 297
2020.03	7 595	2 497	4 489	2 307	1 794
2020.04	12 055	4 460	7 266	3 606	2 777
2020.05	21 358	9 303	11 171	5 366	3 905
2020.06	28 036	6 678	15 250	7 330	4 079

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажлын байрны захиалга

2020 оны 6 сард ирсэн ажлын байрны захиалгыг ААНБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар нь авч үзвэл, 12.4 мянга (44.3 хувь) нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 3.9 мянга (13.8 хувь) нь барилга, 2.2 мянга (7.7 хувь) нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 1.5 мянга (5.4 хувь) нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 1.4 мянга (4.9 хувь) нь Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 1.3 мянга (4.8 хувь) нь боловсруулах үйлдвэрлэл, үлдсэн 5.3 мянга (19.0 хувь) нь бусад салбараар ирсэн байна.

Үйлчилгээний бусд үйл ажиллагааны салбараас ирсэн ажлын байрны захиалга 2020 оны 6 сарын байдлаар 12.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 4.5 мянга буюу 10.9 хувиар хувиар нэмэгдсэн байна.


Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал салбараас ирсэн ажлын байрны захиалга 2020 оны 6 сарын байдлаар 2.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.4 мянга буюу 1.9 дахин нэмэгдсэн байна.

Барилгын салбараас ирсэн ажлын байрны захиалга 2020 оны 6 сарын байдлаар 3.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.2 мянга буюу 47.8 хувиар хувиар нэмэгдсэн байна.

Уул уурхай, олборлолтын салбараас ирсэн ажлын байрны захиалга 2020 оны 6 сарын байдлаар 1.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.5 мянга буюу 78.2 хувиар хувиар буурсан байна.

Боловсруулах үйлдвэрлэлийн салбараас ирсэн ажлын байрны захиалга 2020 оны 6 сарын байдлаар 1.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.5 мянга буюу 53.0 хувиар хувиар буурсан байна.

Зураг 16. Ажлын байрны захиалга, ЭЗҮА-ны салбар, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2020 оны 6 сард ирсэн ажлын байрны захиалгыг ажил мэргэжлийн ангиллаар нь авч үзвэл, 5.6 мянга (20.1 хувь) нь энгийн ажил, мэргэжил, 5.5 мянга (19.5 хувь) нь мэргэжилтэн, 4.8 мянга (17.3 хувь) нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан, 4.3 мянга (15.4 хувь) нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 2.0 мянга (7.0 хувь) нь техникч болон туслах/дэд мэргэжилтэн, 1.9 мянга (6.8 хувь) нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 1.5 мянга (5.5 хувь) нь контор, үйлчилгээний ажилтан, үлдсэн 2.3 мянга (8.3 хувь) нь бусад ажил мэргэжил дээр ажлын байрны захиалга ирсэн байна.

Мэргэжилтэн авах ажлын байрны захиалга 2020 оны 6 сарын байдлаар 5.5 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.7 мянга буюу 43.9 хувиар хувиар нэмэгдсэн байна.

Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан авах ажлын байрны захиалга 2020 оны 6 сарын байдлаар 4.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.1 мянга буюу 20.7 хувиар нэмэгдсэн байна.

Контор, үйлчилгээний ажилтан авах ажлын байрны захиалга 2020 оны 6 сарын байдлаар 1.5 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.0 мянга буюу 56.4 хувиар буурсан байна.

Техникч болон туслах/дэд мэргэжилтэн авах ажлын байрны захиалга 2020 оны 6 сарын байдлаар 1.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 0.9 мянга буюу 31.1 хувиар хувиар буурсан байна.

Зураг 17. Ажлын байрны захиалга, ажил мэргэжлийн ангилал, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар


Ажилд зуучлагдсан иргэн

2020 оны 6 сарын байдлаар 15.3 мянган иргэн ажилд зуучлагдсан бөгөөд насны бүлгээр нь авч үзвэл, 3.4 мянга (20.1 хувь) нь 15-24 насныхан, 4.8 мянга (31.7 хувь) нь 25-34 насныхан, 3.6 мянга (23.6 хувь) нь 35-44 насныхан, 2.4 мянга (16.0 хувь) нь 45-54 насныхан, 0.7 мянга (4.5 хувь) нь 55-59 насныхан, 0.3 мянга (2.2 хувь) нь 60 ба түүнээс дээш насныхан байна.

- Ажилд зуучлагдсан 25-34 насныхан 2019 оны 6 сарын байдлаар 6.2 мянга байсан бол 2020 оны 6 сард 4.8 мянга болж 22.1 хувиар хувиар буурсан байна. Мөн ажилд зуучлагдсан 15-24 насныхан 2019 оны 6 сарын байдлаар 3.9 мянга байсан бол 2020 оны 6 сард 3.4 мянга болж 8.8 хувиар хувиар буурсан байна.
- Ажилд зуучлагдсан 55-59 насныхан 2019 оны 6 сарын байдлаар 494 байсан бол 2020 оны 6 сард 685 болж 3.1 хувиар хувиар өссөн байна.

Тоон мэдээллээс харахад 2020 оны 6-р сарын байдлаар 45-аас дээш насны ажилд зуучлагдсан иргэд өмнөх оноос 486 буюу 16.4 хувиар өссөн байна.

Зураг 18. Ажилд зуучлагдсан иргэд, насны бүлгээр



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2020 оны 6 сард ажилд зуучлагдсан иргэдийг ажил мэргэжлийн ангиллаар нь авч үзвэл, 3.7 мянга (24.0 хувь) нь энгийн ажил, мэргэжил, 3.0 мянга (19.8 хувь) нь мэргэжилтэн, 2.4 мянга (15.9 хувь) нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан, 1.9 мянга (12.3 хувь) нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 1.1 мянга (7.3 хувь) нь техникч болон туслах/дэд мэргэжилтэн, 0.94 мянга (6.2 хувь) нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 0.89 мянга (5.9 хувь) нь контор, үйлчилгээний ажилтан, үлдсэн 1.3 мянга (8.6 хувь) нь бусад ажил мэргэжил дээр ажлын байрны захиалга ирсэн байна.

Ажилд зуучлагдсан мэргэжилтэн 2020 оны 6 сарын байдлаар 3.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 0.2 мянга буюу 7.5 хувиар хувиар нэмэгдсэн байна.

Ажилд зуучлагдсан контор, үйлчилгээний ажилтан 2020 оны 6 сарын байдлаар 0.89 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.5 мянга буюу 62.8 хувиар буурсан байна.


Зураг 19. Ажилд зуучлагдсан иргэд, ажил мэргэжлийн ангилал, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2020 оны 6 сард 28.0 мянга ажлын байрны захиалга ирсэн бөгөөд 15.3 мянган иргэнг зуучилж эрэлтийг хангасан.

Зураг 20. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэдийн тоо, 2020 оны 6-р сарын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 12.4 мянган ажлын байрны захиалга ирсэн бөгөөд 5.1 мянган иргэнг ажилд зуучилсан байна.

Барилгын салбарт 3.9 мянган ажлын байрны захиалга ирсэн бөгөөд 2.1 мянган иргэнг ажилд зуучилсан байна.

Хүснэгт 9. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэдийн тоо, 2020 оны 6-р сарын байдлаар

ЭЗҮА-ны салбарын ангилал	Ажлын байрны захиалга	Ажилд зуучлагдсан иргэд	Хувь
Бүгд	28036	15250	54.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	12429	5103	41.1
Барилга	3860	2101	54.4
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2159	1295	60.0
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1525	1123	73.6
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1375	1201	87.3
Боловсруулах үйлдвэрлэл	1349	865	64.1
Уул уурхай, олборлолт	980	616	62.9
Боловсрол	875	705	80.6
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	794	527	66.4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	617	459	74.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	430	108	25.1
Бусад	1643	1147	69.8

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

БҮЛЭГ 4. ТООЦООЛОГДОХ ЕРӨНХИЙ ТЭНЦВЭРИЙН ЗАГВАР

Судалгааны арга зүй

Судалгаанд ашигласан үндсэн арга зүй нь Тооцоологдох Ерөнхий тэнцвэрийн загвар (Computable General Equilibrium) юм. Энэ загвар нь эдийн засгийн бодлого болон шокийн нөлөөг үнэлэхэд тохиромжтой шинжилгээний хэрэгсэл юм.

CGE загварын онцлог, шинж чанарууд:

- Тооцоологдох гэдэг нь тоон утгаар шийдийг олон гэсэн санааг илэрхийлнэ
- Ерөнхий гэдэг нь эдийн засгийг бүхэлд нь авч үздэг гэсэн утгатай (үндэсний тооцооны системд багтсан бүх үйлдвэрлэл, хэрэглээ, хөрөнгө оруулалт, худалдаа орно)
- Тэнцвэр гэдэг нь
 - Бүх зах зээл (бүтээгдэхүүний зах зээл, хүчин зүйлийн зах зээл, санхүүгийн зах зээл) нэгэн зэрэг тэнцвэрт байна гэсэн санааг илэрхийлнэ. *Эрэлтийн тоо хэмжээ=Нийлүүлэлтийн тоо хэмжээ*
 - Эдийн засгийн бүх агентууд (өрх, пүүс, засгийн газар, гадаад сектор) өөрсдийн төсвийн хүрээнд хамгийн оновчтой шийдвэрийг гаргана
 - Агентуудын зарлага нь орлогоор хязгаарлагдана
- Математик талаасаа, CGE загвар нь шугаман болон шугаман бус тэгшитгэлүүдийн систем бөгөөд дараах төрлийн тэгшитгэлүүд багтана:
 - Үйл хөдлөл (жишээ нь: үйлдвэрлэгчийн ашгаа хамгийн их байх нөхцөл, өрхийн ханамжаа хамгийн их байх нөхцөл гэх мэт)
 - Баланс/тэнцвэр (жишээ нь: нийт хуримтлал=нийт хөрөнгө оруулалт, төлбөрийн тэнцэл)
 - Тодорхойлолт (жишээ нь: өрхийн орлого, төсвийн алдагдал)
- Дээрх систем нь тэнцүү тооны хувьсагч, тэгшитгэлтэй буюу квадрат систем бөгөөд шидийг нь дараах хоёр программаар боддог
 - GEMPACK
 - GAMS
- Загвар статик болон динамик хэлбэртэй байна
- Олон салбар, бүтээгдэхүүн, нэг буюу түүнээс дээш төлөөлөгч өрх, ЗГ-ын бодлогын хэрэгсэл (татвар) зэрэг элементүүдтэй
- CGE загварыг ашиглан олон төрлийн шокуудын нөлөөг судалж болно. Жишээ нь:
 - Нүүр, зэс, бензин түлшний дэлхийн зах зээлийн үнэ өөрчлөгдөх,
 - ЗГ-ын зардал өөрчлөгдөх,
 - Татварын хувь өөрчлөгдөх,
 - Ажиллагчдын бүтээмж өөрчлөгдөх,
 - Гадаад шууд хөрөнгө оруулалт,
 - Ган, зуд,
 - Технологийн дэвшил,
 - Хөдөлмөр, капиталын нийлүүлэлт өөрчлөгдөх,
 - Үйлдвэрлэлийн шок,
 - Хөрөнгө оруулалтын шок,
 - Аль нэг салбарыг дэмжин хөгжүүлэх бодлого гэх мэт.

Монгол Улсын эдийн засгийн динамик суурь загвар

Бид энэхүү судалгааны ажлыг 2019 онд Европын холбооны SECIM төслийн тусламжтайгаар Австрали Улсын Бодлогын судалгааны төв (Center of Policy Studies)-тэй хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хамтран хөгжүүлсэн загварыг ашигласан.

Динамик CGE загвар нь ерөнхий тэнцвэрийн загвар тул системийн нэг талд гарсан өөрчлөлт бусад бүх хэсэгт шууд болон шууд бус нөлөө үзүүлнэ. Загварын тавилын үндсэн онцлогуудыг авч үзье.

Загварт үйлдвэрлэлийн олон салбар байна. Салбар бүрийн үйлдвэрлэлийн функц нь олон шаттай бөгөөд шат бүр нь өргөжилтийн тогтмол өгөөжтэй функцууд байна. Тухайлбал, үйлдвэрлэлийн эхний шат нь нэмүү өртөг ба завсрын хэрэглээнээс хамаарсан Леонтивийн функц байна. Дараагийн түвшинд, j салбарын t үе дэх нэмүү өртгийн $(VA_{j,t})$ функц нь технологийн дэвшлийн $(A_{j,t})$ өргөтгөлтэй хөдөлмөр $(L_{j,t})$ ба капиталаас $(K_{j,t})$ хамаарсан орлуулалтын тогтмол мэдрэмжтэй (CES) функц байна.

$$VA_{j,t} = B_j (\beta_j (A_{j,t} L_{j,t})^{\rho_j} + (1 - \beta_j) K_{j,t}^{\rho_j})^{-1/\rho_j} \quad (1)$$

Энд B_j бүтээмжийн параметр, β_j нь хөдөлмөрийн орлогын эзлэх хувийн жингийн параметр бол ρ_j нь орлуулалтын мэдрэмж. $A_{j,t}$ нь j салбарын нийт хүчин зүйлийн бүтээмжийг илэрхийлнэ.

Өсөлтийн стандарт загваруудын адилаар салбар бүрийн капиталын нөөц нь хөрөнгө оруулалтаар нэмэгдэж, элэгдлээр хорогдоно (Тэгшитгэл 2). Төрийн үйлчилгээний салбарууд, уул уурхайн салбарууд, мал аж ахуйн салбарын хөрөнгө оруулалт экзоген бол бусад салбарын өгөөж, элэгдэл, зээлийн хүү зэргээс хамаарч эндогеноор тодорхойлогдоно (Тэгшилгэл 3).

$$KDk_{j,t+1} = KDk_{j,t}(1 - \delta_{k,j}) + INDk_{j,t} \quad (2)$$

$$INDk_{bus,t} = \phi_{k,bus} [Rk_{bus,t} / Uk_{bus,t}] \sigma_{k,bus} * KDk_{bus,t} \quad (3)$$

Энд $IND_{k,bus,t}$ нь t үеийн j салбарын хөрөнгө оруулалтын эрэлт юм.

Нийт хөдөлмөрийн нийлүүлэлт нь хүн амын өсөлттэй адил хувиар өсөх бөгөөд уг өсөлт нь экзоген байна. Хөдөлмөр нь хугацааны аль ч үед салбар хооронд чөлөөтэй шилжих боломжтой хүчин зүйл байна.

Бүтээгдэхүүн бүрийн завсрын хэрэглээ нь салбарын үйлдвэрлэлтэй пропорциональ байна. Салбар бүр олон бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд тэдгээр нь шилжилтийн тогтмол мэдрэмжтэй (SET) функцээр нэгтгэгдэнэ. Дотоодын нийлүүлэлт, экспортын харьцаа нь мөн SET функц болон харьцангуй үнүүдээр тодорхойлогдоно.

Харин эрэлт талдаа, дотоодын барааны хэрэглээ, импортын харьцаа нь CES функцээр тодорхойлогдоно. Хөрөнгө оруулалт болон засгийн газрын хэрэглээний нийт эрэлт нь бараануудад тогтмол хувиар хуваагдана. Хөрөнгө оруулалтын эрэлт нь үндсэн хөрөнгийн хэрэглээ, эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт гэж хуваагдана. Дотоодын барааны экспортын эрэлт нь харьцангуй үнээс хамаарна (гадаад үнэ/дотоод үнэ).

Засгийн газар шууд болон шууд бус татвар (үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, гадаад худалдааны татварууд), бусад агентаас ирэх шилжүүлгээс орлого олж, түүнийгээ хадгаламж, урсгал зардал гэх мэт зүйлсэд хуваарилна.

Тоон өгөгдөл

CGE загварын үндсэн тоон өгөгдөл нь Нийгмийн Тооцооллын Матриц (Social Accounting Matrix) юм. НТМ-ыг Нөөц ба Ашиглалтын хүснэгтүүд, төлбөрийн тэнцэл болон нэгдсэн төсвийн тоон өгөгдлийг ашиглан байгуулдаг. Бидний ашиглаж буй загварт 2015 оны Нөөц ба Ашиглалтын хүснэгт (68x55 хэмжээтэй) болон бусад тухайн оны шаардлагатай тоон өгөгдлүүдийг ашиглан загварын тоон өгөгдлийг байгуулсан.

Энэхүү тоон өгөгдөл нь дэх данснууд нь 32 салбар/бүтээгдэхүүн (уул уурхайн салбарыг нүүрс ба газрын тос, металлын хүдэр, бусад уул уухай гэж задалж оруулсан); 2

хүчин зүйл (хөдөлмөр ба капитал); 3 төрлийн институт (хувийн сектор, засгийн газар ба гадаад сектор); 3 төрлийн татвар (орлогын татвар, импортын тариф, бүтээгдэхүүний татварууд); мөн төрийн болон хувийн хөрөнгө оруулалт, нөөцийн өөрчлөлтөөс бүрдэх хадгаламжийн (хөрөнгө оруулалтын) данснуудаас бүрдэнэ.

Хүснэгт 9-д 15 данснаас бүрдэх макро матрицыг 2015 оны нэрлэсэн ДНБ (23 их наяд төгрөг)-д эзлэх хувь хэлбэрээр харуулж байна. Мөрийн дагуу данс бүрийн орлогыг харуулж байгаа бол баганын дагуу данс бүрийн зарлагыг харуулна. Өрхийн хэрэглээ болон засгийн газрын хэрэглээ ДНБ-ны 70 орчим хувьтай тэнцэж байна (харгалзан 53.5 ба 12.7 хувь). Үндсэн хөрөнгийн хуримтлал (төрийн болон хувийн) болон нөөцийн өөрчлөлт нийтдээ ДНБ 38 хувьтай тэнцүү байна. Экспорт болон импортын аль аль нь ДНБ-ний талаас илүү хувь байна (харгалзан 59 ба 56). Эдийн засаг бүхэлдээ капитал болон хөдөлмөрийн ойролцоо багтаамжтай байна. Өөрөөр хэлбэл капитал эзэмшигчид төлсөн төлбөр ба ажиллагчдын цалин хөлс аль аль нь ДНБ-ний 45 хувь орчим байна. Нэмүү өртгийн ДНБ-д эзлэх хувь 90.5 хувь байсан бол үлдсэн 9.5 хувийг бүтээгдэхүүний шууд бус татвар (7.4 хувь), импортын тариф (1.7 хувь), үйлдвэрлэлийн цэвэр татвар (0.4 хувь) бүрдүүлсэн байна.

Хүснэгт 10. 2015 оны макро хүснэгт (ДНБ-д эзлэх хувь)

№	Салбар/бүт	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1	Хөдөлмөр								0.6	45.2						46
2	Капитал								0.1	45.4						46
3	Өрхүүд	44.8	33.6		11.6				2.1							92
4	ЗГ			3.2	13.1	1.7	7.4	0.2	0.4		0					26
5	Шууд татвар			13.1												13
6	Импортын тариф										1.7					2
7	ШБТ										7.4					7
8	Гадаад сектор	0.9	11.9	0.7	2						56.3					72
9	Салбарууд										126	53.8				180
10	Бүтээгдэхүүнүүд			53.5	12.7					89.1	15.2	4.9	18.7	5.9	6.7	207
11	Экспорт								58.7							59
12	Хувийн ХО			17.4	-0.3				8.3							25
13	Төрийн ХО			4	-0.1				1.9							6
14	Нөөцийн өөрчлөлт												6.7			7
15	НИЙТ	46	46	92	39	2	7	0	72	180	207	59	25	6	7	

Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Үйлдвэрлэлийн бүтэц: Мал аж ахуй, худалдаа болон төрийн үйлчилгээний салбарууд хөдөлмөрийн орлогын дийлэнхийг бүрдүүлсэн бөгөөд хөдөлмөрийн өндөр багтаамжтай салбарууд байна. Харин нүүрс ба газрын тос, металлын хүдэр, боловсруулах үйлдвэрлэл, санхүүгийн салбарууд нь капиталын орлогын дийлэнхийг бүрдүүлсэн бөгөөд капиталын багтаамж өндөртэй салбарууд байна (Хүснэгт 10). Дээр дурдсанчлан эдийн засаг бүхэлдээ хөдөлмөр, капиталын ойролцоо багтаамжтай байна.

Хүснэгт 11. Үйлдвэрлэлийн бүтэц, хувиар

Салбарууд	Хөдөлмөр	Капитал	Нэмүү өртөг	Нэмүү өртөг/Нийт гарц	ХЗ багтаамж	
					Хөд.	Кап.
Газар тариалан	0.8	1.0	0.9	41.0	43.2	56.8
Мал аж ахуй	19.2	1.7	10.5	70.9	91.7	8.3
Нүүрс ба газрын тос	1.5	19.1	10.3	54.4	7.3	92.7
Металлын хүдэр	6.6	22.6	14.6	55.2	22.5	77.5
Бусад уул уухай	0.7	0.8	0.8	31.3	47.3	52.7
Боловсруулах	5.6	14.2	9.9	36.8	28.2	71.8
Цахилгаан, ус хангамж	2.9	1.8	2.4	28.7	61.9	38.1
Барилга	4.9	3.3	4.1	24.2	59.7	40.3
Худалдаа	20.7	4.3	12.5	55.4	82.8	17.2
Санхүү	6.0	21.4	13.7	70.3	21.8	78.2
Төрийн үйлчилгээ	17.1	4.9	11.0	64.1	77.6	22.4
Бусад үйлчилгээ	13.9	4.8	9.4	41.1	74.2	25.8
НИЙТ	100	100	100	50.3	49.9	50.1

Худалдааны бүтэц: Хүснэгт 11-д гадаад худалдааны бүтцийг харуулж байна. Металлын хүдэр, нүүрс, газрын тосны экспорт нийт экспортын талаас илүүг бүрдүүлсэн (59 хувь) бол боловсруулах салбарын болон санхүүгийн бүтээгдэхүүний импортын 78 хувийг бүрдүүлжээ. Металлын хүдэр, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүнүүдийн дийлэнх нь экспортлогддог бол бусад уур уурхайн бүтээгдэхүүн 100 хувь импортлогдсон байна.

Хүснэгт 12. Худалдааны бүтэц, хувиар

Салбарууд	Экспорт	Импорт	Экспортын эрчимжилт	Импортын нэвтрэлт
Газар тариалан	0.9	1.4	25.6	35.6
Мал аж ахуй	3.4	0.2	13.6	0.8
Нүүрс ба газрын тос	26.7	0.0	85.1	0.0
Металлын хүдэр	32.8	0.0	95.0	0.0
Бусад уул уухай	1.2	0.1	100.0	100.0
Цахилгаан, ус хангамж	0.0	2.1	0.0	13.5
Боловсруулах	21.4	66.9	35.1	66.1
Барилга	0.4	3.7	1.4	12.1
Худалдаа	4.2	5.8	12.7	16.1
Санхүү	3.5	11.5	9.0	23.8
Төрийн үйлчилгээ	0.2	2.1	0.8	7.2
Бусад үйлчилгээ	5.2	6.3	16.9	19.1
НИЙТ	100	100		

Эрэлтийн бүтэц: Хүснэгт 12-д бүтээгдэхүүн бүрийн эрэлтийн бүтцийг харуулж байна. Газар тариалан, санхүү болон боловсруулах салбарын бүтээгдэхүүн өрхийн хэрэглээнд хамгийн

өндөр хувьтай зарцуулагдсан бол төрийн үйлчилгээний талаас илүүг засгийн газар худалдан авсан. Нүүрс, газрын тос, санхүү, газар тариалан болон цахилгаан, усан хангамжийн бүтээгдэхүүний дийлэнх нь завсрын хэрэглээнд зарцуулагдсан. Бусад уул уурхай болон боловсруулах салбарын бүтээгдэхүүний хувьд мөн завсрын хэрэглээнд голдуу хэрэглэгдсэн. Худалдаа үйлчилгээний 80.7 хувь нь худалдааны нэмэгдэл болсон бол бусад үйлчилгээний 8.4 хувь нь мөн нэмэгдэл болсон. Харин барилгын үйлчилгээ нь голдуу хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдсан.

Хүснэгт 13. Эрэлтийн бүтэц, хувиар

Салбарууд	Өрхийн хэрэглээ	ЗГ-ын хэрэглээ	Засврын хэрэглээ	Нэмэгдэл	ҮХХ	НӨ
Газар тариалан	41.1	0.0	69.3	0.0	0.1	-10.5
Мал аж ахуй	23.8	0.0	36.8	0.0	26.2	13.3
Нүүрс ба газрын тос	4.3	0.0	67.6	0.0	0.0	28.1
Металлын хүдэр	0.0	0.0	5.8	0.0	0.0	94.2
Бусад уул уухай	3.6	0.0	565.1	0.0	0.0	-468.7
Цахилгаан, ус хангамж	6.6	2.0	91.4	0.0	0.0	0.0
Боловсруулах	35.5	0.1	47.1	0.0	12.5	4.8
Барилга	0.1	0.0	37.1	0.0	62.8	0.0
Худалдаа	13.4	0.0	5.9	80.7	0.0	0.0
Санхүү	37.4	2.0	57.9	0.0	2.7	0.0
Төрийн үйлчилгээ	25.4	69.3	5.4	0.0	0.0	0.0
Бусад үйлчилгээ	23.8	2.4	65.4	8.4	0.0	0.0

Засгийн газрын орлого, зарлагын бүтэц: Засгийн газар орлогынхоо 63 хувийг өрхүүдээс шууд татвар (50.5 хувь) болон шилжүүлэг (12.2 хувь) хэлбэрээр хүлээн авсан. Орлогын бусад эх үүсвэр харьцангуй ижил байна. Засгийн газар орлогынхоо тал орчмыг бараа үйлчилгээ худалдан авахад зарцуулсан бол 44 хувийг нь өрхүүдэд шилжүүлэг хэлбэрээр өгсөн. Төсвийн нийт урсгал зардал орлогоосоо 1.3 хувиар давсан байна.

Хүснэгт 14. Төсвийн бүтэц, хувиар

Төсвийн орлого		Төсвийн зарлага	
Өрхүүдээс ирэх шилжүүлэг	12.1	Өрхүүдрүү хийх шилжүүлэг	44.6
Шууд татвар	50.5	Гадаад сектор луу хийх шилжүүлэг	7.7
Импортын тариф	6.7	ЗГ-ын худалдан авалт	49.0
Экспортын татвар	0.0	Хадгаламж	-1.3
Бүтээгдэхүүний цэвэр татвар	28.4		
Гадаад сектороос ирэх шилжүүлэг	0.8	НИЙТ	100.0
Үйлдвэрлэлийн цэвэр татвар	1.5		
НИЙТ	100.0		

Өрхийн (хувийн секторын) орлого, зарлагын бүтэц: Өрхүүдийн хувьд орлогын гол эх үүсвэр нь капиталын эзэмшил ба хөдөлмөр бөгөөд тэдгээр нь өрхийн нийт орлогын 85 орчим хувийг бүрдүүлсэн (Хүснэгт 14). Өрхүүд орлогынхоо 14 хувийг шууд татвар хэлбэрээр төлсөн бол 3.4 хувийг нь татвараас бусад төлбөр хэлбэрээр мөн төсөвт төлсөн. Өрхийн хадгаламж нь орлогынхоо 23 орчим хувь байсан бол гадаад сектор луу явуулсан шилжүүлэг харьцангуй бага хувийг эзэлсэн (0.7 хувь).

Хүснэгт 15. Өрхийн орлого, зарлага, хувиар

Өрхийн орлого		Өрхийн зарлага	
Цалин хөлс	48.7	Хэрэглээ	58.2
Капиталын орлого	36.5	Шууд татвар	14.3
ЗГ-аас авсан шилжүүлэг	12.6	ЗГ-луу хийсэн шилжүүлэг	3.4
Гадаад сектороос авсан шилжүүлэг	2.0	Гадаад сектор луу хийсэн шилжүүлэг	0.8
НИЙТ	100	Хадгаламж	23.4
		НИЙТ	100

Хөрөнгө оруулалт/Хадгаламжийн бүтэц: Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн дийлэнхийг (68.2 хувь) өрхийн хадгаламж бүрдүүлсэн бол гадаад секторын хадгаламж 33 хувийг бүрдүүлсэн (Хүснэгт 15). Хөрөнгө оруулалтын зардлын 67 хувь нь хувийн хөрөнгө оруулалтыг (үндсэн хөрөнгийн хуримтлал) санхүүжүүлсэн. Төсвийн хөрөнгө оруулалт болон нөөцийн өөрчлөлтөд нийт хөрөнгө оруулалтын зардлыг нь харгалзан 15 болон 17 хувь зарцуулагдсан.


Хүснэгт 16. Хөрөнгө оруулалт/Хадгаламжийн бүтэц, хувиар

Эх үүсвэр		Зарцуулалт	
Өрхүүд	68.5	Хувийн хөрөнгө оруулалт	66.8
Засгийн газар	-1.1	Төсвийн хөрөнгө оруулалт	15.5
Гадаад сектор	32.6	Нөөцийн өөрчлөлт	17.7
НИЙТ	100	НИЙТ	100

COVID-19 цар тахлын монгол улсын эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх нөлөөний үнэлгээ

CGE загварыг ашиглан макро эдийн засгийн урт хугацааны буюу 10 жилийн суурь төсөөлөл болон COVID-19 цар тахлын нөлөөг агуулсан алтернатив хувилбаруудыг боловсрууллаа. Алтернатив хувилбарын үр дүнг суурь хувилбарын үр дүнтэй харьцуулах замаар бид COVID-19 цар тахлын эдийн засаг болон хөдөлмөрийн зах зээл дэх нөлөөг үнэлсэн. Тодруулбал, дараах зурагт харуулсан байдлаар суурь хувилбар болон алтернатив хувилбарын ялгаа нь COVID-19 цар тахлын нөлөөг илэрхийлнэ.

Зураг 21. Шинжилгээний арга



Дээрх аргачлалын дагуу COVID-19 цар тахлын нөлөөг үнэлэхдээ эдийн засгийн 10 жилийн (2020-2030) төсөөллийг дараах хувилбараар боловсруулсан:

- Суурь хувилбар: COVID-19 цар тахлын нөлөө байхгүй
- Хувилбар 1: COVID-19 цар тахлын нөлөө байгаа

Суурь хувилбар

Энэ хувилбарт COVID-19 цар тахлын нөлөө байхгүй гэж үзнэ – ө.х., Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал хэвийн тогтвортой үргэлжилнэ.

Хувилбар 1: COVID-19 цар тахлын нөлөө

Энэ хувилбарт бид COVID-19 цар тахлын нөлөөг Монгол Улсын макро эдийн засгийн зарим үзүүлэлтүүдэд тусгаж өгсөн.


- Уул уурхайн салбар (Нүүрс ба газрын тос, металлын хүдэр, бусад уул уурхай)-ын экспортыг 25 хувиар бууруулах
- Аялал жуулчлалтай зогссонтой холбогдуулан зарим салбар (Тээвэр, Зочид буудал, нийтийн хоол, Мэргэжлийн болон ШУ, техникийн үйл ажиллагаа, Бусад үйлчилгээ)-ын бүтээгдэхүүн үйлчилгээний орлогыг 60 хувиар бууруулах

Үр дүн


COVID-19 цар тахлын нөлөө Монгол Улсын макро эдийн засгийн хувьсагчдад үзүүлэх нөлөөг харуулна. Зураг 6-д бодит ДНБ-ий өсөлтийн төсөөллийг хувилбар бүрээр харуулж байна. Суурь хувилбарт ДНБ-ны ирэх 11 жилийн өсөлт аажмаар саарч 4.5 хувь орчимд тогтворжих төлөвтэй байсан бол Хувилбар 1-т 2020 оны бодит ДНБ-ий өсөлт 0.46 хувь хүртэл буурч 2021 онд 10.5 хувийн өсөлттэй байхаар төсөөлөгдсөн байна.

Хувилбар 1-т бид ашигт малтмалын экспортыг 25 хувиар бууруулсан бол уг шок Монгол Улсын нийт экспортын хэмжээг 2020 оны байдлаар 2.7 хувиар бууруулахаар байна. 2021 онд бүтээгдэхүүн, үйлчилгээний экспорт сэргэж 6.1 хувийн өсөлт үзүүлж цаашдаа тогтвортой байхаар байна.

Зураг 22. Бодит ДНБ-ий өсөлт, хувь



Зураг 23. Экспортын өсөлт, хувь



COVID-19 цар тахлын макро үзүүлэлтүүдэд үзүүлэх нөлөөг Хүснэгт 9-өөс илүү тодорхой харж болно. Хувилбар 1-ын нөлөө сонгогдсон макро хувьсагчдад төдийлөн хүчтэй нөлөөлөөгүй боловч хэлбэлзлийн нөлөөг нэмэх нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 17. Хувилбаруудыг харьцуулах нь: Макро эдийн засгийн хувьсагчид

Макро хувьсагчид	Дундаж өсөлт	
	Суурь	Хувилбар 1
Бодит ДНБ	5.263	5.217
Өрхийн хэрэглээ	4.793	4.894
Засгийн газрын хэрэглээ	4.793	4.793
Хөрөнгө оруулалт	4.793	5.279
Экспорт	4.793	4.704
Импорт	3.398	4.036
Хөдөлмөр эрхлэлт	0.135	0.127

ДҮГНЭЛТ

Манай Улсын Хөдөлмөрийн зах зээлд “Covid-19” цар тахал нөлөөлж байгаа эсэхийг захиргааны тоон мэдээлэл болон “Монгол Улсын эдийн засгийн динамик суурь загвар”-аар авч үзлээ.

Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч аж ахуй, нэгж байгууллагын тоо өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өссөн, даатгуулагчийн тоо 0.1 хувиар буурсан хэдий ч шимтгэлийн орлого нь өмнөх оны мөн үеэс 107.3 тэрбум төгрөг буюу 12.9 хувиар буурсан дүнтэй байна. Эндээс харахад аж ахуй, нэгж байгууллагууд 2020 оны 3-р сарын 27-ны Засгийн газрын ээлжит бус хуралдаанаас гарсан 2020.04.01-ээс 2020.10.01 хүртэлх 6 сарын хугацаанд аж ахуй, нэгж байгууллагуудын шимтгэлийг тэглэх шийдвэрт хамрагдахын тулд ажиллагчдынхаа цалинг бууруулах, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нийгмийн даатгалын шимтгэлийг нь төлж амралт өгсөн байх магадлалтай байна. Энэхүү таамаглалыг НДЕГ-аас бэлтгэн гаргадаг цалин хөлсний захиргааны тоон мэдээ зарлагдагдахад тодруулан, шинжлэх боломж бүрдэх юм.

Мөн сайн дурын даатгуулагч 2019 оны 2-р улиралд 21.8 мянгаар нэмэгдэж байсан бол 2020 оны 2-р улиралд 48.5 мянгаар нэмэгдэж, өмнөх оны 2-р улиралтай харьцуулж үзэхэд 2.2 дахин өссөн байна. Тоон мэдээллээс харахад 2020 оны 3-р сарын 27-ны Засгийн газрын ээлжит бус хуралдаанаар дөрөвдүгээр сарын 1-ээс аравдугаар сарын 1-ний өдөр хүртэл сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөнд тооцно гэсэн шийдвэрийн нөлөөг харж болохоор байна.

Ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо 2020 оны 6 сарын байдлаар 10.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 106 буюу 0.1 хувиар буурсан боловч ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулсан хөрөнгө өмнөх оны мөн үеэс 6.8 тэрбум буюу 35.8 хувиар өссөн дүнтэй байна. Эндээс үзэхэд өндөр цалин, хөлстэй ажиллагчид ажлаасаа гарч ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан байх магадлалтай юм.

Ажил хайгч иргэдийн тоо мэдээллээс харахад 2020 оны 6-р сарын эцэст 30.3 мянган иргэн ажил хайж байсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.0 мянга буюу 9.0 хувиар буурсан байна. Ажил хайгч иргэдээс ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 2.6 мянга буюу 39.2 хувиар буурсан. Мөн бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажилд зуучлагдсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 36.3 хувиар буурсан байна.

2020 оны эхний хагас жилийн байдлаар ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар нэмэгдсэн хэдий ч ажилд зуучлагдсан иргэд 9.8 хувиар буурсан дүнтэй байна. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр сургууль болон цэцэрлэгийн үйл ажиллагааг хаасантай холбоотойгоор иргэд бага насны хүүхдээ харахын тулд эсвэл эрүүл мэнддээ анхаарч ажил хайхгүй байх, ажил хийх сонирхолгүй байх магадлалтай юм.

Монгол улсын эдийн засгийн динамик суурь загвар-CGE

Энэхүү судалгаагаар бид CGE загварыг ашиглан COVID-19 цар тахлын Монгол Улсын эдийн засаг дах нөлөөг судаллаа. Цар тахлын нөлөө нь манай улсын нийгэм, эдийн засгийн байдалд шууд болон шууд бус нөлөө үзүүлж байгаа. Бид бодит байдалд тулгуурлан уул уурхайн экспорт болон аялал жуулчлал, түүнийг дагасан бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтэд шок өгөх замаар шууд болон шууд бус нөлөөг харахыг зорьсон билээ. Судалгааны үр дүнгээс харахад бодит ДНБ, өрхийн хэрэглээ, импорт, экспортын өсөлт 2020 онд огцом буурч байгаа бөгөөд бусад макро хувьсагчдын цаашдын дундаж өсөлтийг суурь хувилбартай харьцуулахад сөрөг нөлөөтэй байна. Харин загварт дунд хугацааны хөдөлмөрийн зах зээлийн нөлөөг үзэх тэгшитгэлийг сайжруулан, өргөтгөх ажил хийгдэж байна.